



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Одонгийн ЦОГТГЭРЭЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-34-14, Факс: 32-70-16
E-mail: tsogtgerelo@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026. 06. 05 № УИХ-03/6494
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай


Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль”-ийн төсөл санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын холбогдох байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хавсралт ¹⁰¹ хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

Б.ЖАРГАЛАН

2026000103



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Одонгийн ЦОГТГЭРЭЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-34-14, Факс: 32-70-16
E-mail: tsogtgerelo@parliament.mn
http://www.parliament.mn

2026. 06. 04 № УИХ-03/6462
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд “Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль”-ийн төсөл санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 101 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.ЦОГТГЭРЭЛ

Б.ЖАРГАЛАН

Г.ОЧИРБАТ

2026000128



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
О.ЦОГТГЭРЭЛ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2025.12.30 № ХТ/3683

танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Таны санаачлан боловсруулсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 34 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“15.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс санаачлан боловсруулсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэлээс санаачлан боловсруулсан Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагчид уламжлахаар тогтов:

1.Хуулийн төслийн агуулга нь Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэж байх тул уг хуулийн төсөлтэй нэгтгэн хэлэлцүүлэх;

2.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэж, Иргэний хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсэгт “Монгол Улсад нийтийн болон хувийн өмч байна” гэж, мөн зүйлийн 99.2 дахь хэсэгт “Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна” гэж, мөн зүйлийн 99.3 дахь хэсэгт “Хувийн өмч нь иргэний болон дундын гэсэн хэлбэртэй байна” гэж тус тус заасан.

Дээрх хуульд зааснаар хувийн өмч нь өмчлөлийн зүйлээ өөрийн үзэмжээр чөлөөтэй эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулах туйлын эрхэд тулгуурладаг бол нийтийн өмч болох төрийн болон орон нутгийн өмч нь ард түмнийг төлөөлөн өмчийн удирдлагыг хуульд заасны дагуу хэрэгжүүлэх замаар эзэмшиж, ашиглаж, захиран зарцуулдгаараа ялгаатай бөгөөд төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулдаг.

Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “... нийтийн болон хувийн өмчийн тэгш эрхийг хангуулах” гэж, мөн төслийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт “Нийтийн болон хувийн өмчийн эзэмшигчийн эрх хэмжээ ижил тэнцүү байна” гэж тусгасан нь Монгол Улсын Үндсэн хууль болон Иргэний хуулийн холбогдох заалттай нийцэхгүй байгааг анхаарах;

3.Хуулийн төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт өмчийг өмчийн эзний зөвшөөрөл, шүүхийн шийдвэргүйгээр дайчлах, төрийн мэдэлд шилжүүлэхийг хориглохоор тусгасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт “... Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж заасантай нийцэхгүй байх тул дахин нягтлах;

4.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл энэ хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан тусгай болон энгийн зөвшөөрөлтэйгөөр эрхлэхээс бусад төрлийн үйл ажиллагааг хууль

тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болно” гэж заасан тул хуулийн төслийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг бизнесийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болох агуулгаар өөрчлөн найруулах;

5.Европын холбоо, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын орнуудын туршлагад үндэслэн бизнесийн зөвшөөрөл, бүртгэл, хяналт, шалгалттай холбоотой журам, шаардлага, шийдвэрийн хэрэгжилтийг ил тод, нээлттэй байлгах, иргэн, хуулийн этгээдэд адил тэгш хандах зарчмыг хуулийн төслийн 3 дугаар зүйлд тусгах;

6.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт хууль, Улсын Их Хурлын шийдвэрээр баталснаас бусад тохиолдолд төрийн өмчит компани байгуулахыг хориглохоор, хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан “Аж ахуйн үйл ажиллагаанд оролцох төрийн оролцоог хязгаарлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын тооны дээд хязгаарыг тогтоох, шинээр үүсгэн байгуулах, өөрчлөн байгуулах тохиолдолд өөр нэгийг хувьчлах, татан буулгах зарчмыг баримтлахаар тусгасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах шийдвэрийг гаргах Засгийн газрын бүрэн эрхтэй зөрчилдөхөөр байна.

Түүнчлэн, хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан “Төрийн өмчит аж ахуйн нэгжийн жагсаалт батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд жагсаалт тусгагдаагүй, мөн төр оролцох шаардлагагүй салбаруудад аж ахуйн үйл ажиллагаа явуулан хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчидтай өрсөлдөхгүй байхаар заасан боловч төр оролцох шаардлагагүй салбар гэдэгт аль салбар хамаарахыг тодорхой заагаагүй байгааг анхаарах;

7.Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл /Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл/-д Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт заасан ашгийн төлөө хуулийн этгээдийн хэлбэрийг зөрчсөн “үйлдвэрийн газар” гэх төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хэлбэрийг байхгүй болгож, төр, орон нутгийн өмчийн эзэмшигч нь төрийн болон орон нутгийн байгууллага, төрийн болон орон нутгийн нийтийн үйлчилгээний байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компани хэлбэртэй байхаар, Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төсөлд төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулах үндэслэл, өөр үндэслэлээр төрийн болон орон нутгийн өмчит компани үүсгэн байгуулахыг хориглох зэрэг асуудлыг тусгасан. Иймд Засгийн газраас баримталж байгаа төрийн өмчийн шинэчлэлийн бодлогын хүрээнд хуулийн төслийн 4.1-д заасан асуудлыг холбогдох хуулийн төслүүдтэй уялдуулан нэг мөр шийдвэрлэх нь зүйтэй;


8.Үзэл баримтлалын төсөлд “Хуулийн төсөл батлагдсанаар хувийн өмчид дураар шууд халдах явдал багасаж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулах явдал хумигдаж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаагаа явуулах, ажил бизнестээ хандах итгэл нэмэгдэх болно” гэж тусгасан боловч уг зарчим, зорилтыг хэрхэн хэрэгжүүлэх, төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүд хооронд үүсэх эрх, үүргийн харилцаа, хууль хэрэгжүүлэх нарийвчилсан зохицуулалтуудыг холбогдох хууль тогтоомжид бүрэн тусгаагүй байна;

9.Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөл боловсруулах, хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй байна. Тодруулбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, батална” гэж заасан боловч хууль санаачлагч хуулийн төслийн үзэл баримтлалыг батлаагүй байна.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх гэж, мөн зүйлийн 29.1.6 дахь заалтад хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байхаар заасан хуулийн шаардлагад нийцэхгүй, хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан “Чөлөөт зах зээлийг хөгжүүлж, хувийн өмч, эдийн засгийн эрх чөлөөт хамгаалах тухай “Иргэн нь баян Монгол”” Улсын Их Хурлын тогтоолын төсөлд “Улсын Их Хурал, Засгийн газраас өргөн баригдах хууль, тогтоолын төслүүд уг тогтоолд багтсан томъёоллыг дэмжих хэлбэрээр байхыг заасугай.” гэсэн нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9.1 дэх заалтад заасан тухайн хууль тогтоомжийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон хууль зүйн бодлогод нийцсэн байх шаардлагыг хангахгүй байна.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хууль нь “хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм”-ийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгосон. Энэхүү эрхэм зорилгын эдийн засгийн үндэс нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь ... хувийн өмчид тулгуурласан ... олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “... хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хувийн өмчлөх”, 4 дэх хэсэгт “...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж тус тус тунхаглан баталгаажуулсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр заалт нь хувийн өмч, хувийн санаачилга, шударга өрсөлдөөнд тулгуурласан зах зээлийн эдийн засгийн тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоосон билээ. Гэвч эдгээр үндсэн зарчмыг хэрэгжүүлэх, бодит агуулгаар хангах үүрэг бүхий хууль тогтоомж нь сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд салангид байдлаар хөгжиж, эдийн засгийн эрх чөлөөг хамгаалах нэгдмэл үзэл баримтлал, суурь зарчим хангалттай бүрдээгүй байна. Үүний улмаас Үндсэн хуульд тунхагласан эдийн засгийн эрх, эрх чөлөөний баталгаа болон түүний бодит хэрэгжилтийн хооронд тодорхой зөрүү үүсэж, эдийн засгийн харилцаанд эрх зүйн тогтвортой байдал, урьдчилан таамаглах боломж, төрийн хэт их оролцоо, төрийн өмчит компаниудын давамгайлалтай байдалтай холбоотой бодит хүндрэлүүд бий болжээ.

“Эдийн засгийн эрх чөлөөний тухай” хуулийн төсөл нь Үндсэн хуулийн үзэл санааг өдөр тутмын харилцаанд хэрэгжүүлэх, эдийн засгийн эрх чөлөөнд ямар тохиолдолд хязгаарлалт тогтоож болох, түүнийг хэрхэн хамгаалах зэрэг нарийвчилсан механизмыг бий болгох зорилготой ерөнхий хууль юм.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бүтээмж, хувийн хэвшлийн хөгжлийн үндэс нь эдийн засгийн эрх чөлөө, өмчийн эрхийн баталгаа, гэрээний тогтвортой байдал, шударга өрсөлдөөн юм. Иймд хүний эдийн засгийн суурь эрх, эрх чөлөөг хамгаалах, төрөөс эдийн засгийг зохицуулах үйл ажиллагааны зорилго, хэлбэр, хязгаарыг тодорхой болгох, эдийн засгийн харилцаанд эрх зүйн тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой орчныг бүрдүүлэх, төр болон хувийн хэвшлийн харилцаанд хариуцлага, ил тод байдлыг бэхжүүлэх зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Нэгдүгээрт, Үндсэн хуульд баталгаажуулсан эдийн засгийн эрх, эрх чөлөөг бодит эрх зүйн баталгаагаар хангахыг зорьсон. Хуулийн төсөл нь Үндсэн хуульд заасан хувийн өмчлөх эрхийн агуулгыг тодорхой болгож, өмчлөгчийн эрхийг төрийн хууль бус болон дур зоргын оролцооноос хамгаалах, өмчид халдсан тохиолдолд шударга нөхөн төлбөр олгох, өмчийн халдашгүй байдлыг хангах эрх зүйн баталгааг бүрдүүлнэ. Түүнчлэн аж ахуй эрхлэх эрхийг төрөөс зөвшөөрөл олгосноор бий болдог боломж бус, харин хуулиар хориглоогүй тохиолдолд хүн бүр эдлэх суурь эрх болохыг хуульчилж, энэхүү эрхийг хязгаарлах аливаа арга хэмжээ нь хуульд үндэслэсэн, нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай, ялгаварлан гадуурхахгүй, зорилгодоо нийцсэн байх шалгуурыг хангасан байх зарчмыг тогтоож байна. Ийнхүү хуулийн төсөл нь Үндсэн хуульд тунхагласан эдийн засгийн эрх чөлөөний үзэл санааг бодит хэрэгжилтээр хангах, эдийн засгийн харилцаанд эрх зүйн тодорхой, тогтвортой орчныг бүрдүүлэхэд чиглэж байна.

Хоёрдугаарт, эдийн засгийн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн дотоод уялдаа, нэгдмэл байдлыг хангах эрх зүйн суурийг бүрдүүлэхийг зорьсон. Сүүлийн жилүүдэд татвар, зөвшөөрөл, өрсөлдөөн, хөрөнгө оруулалт болон эдийн засгийн бусад харилцааг зохицуулсан хууль тогтоомж салбар тус бүрээр хөгжиж ирсэн боловч тэдгээрийг тайлбарлах, хэрэглэхэд баримтлах нийтлэг зарчим, нэгдсэн хандлага хангалттай бүрдээгүй байна. Үүний улмаас хууль тогтоомжийн хэрэглээнд зөрүүтэй тайлбар, эрх зүйн тодорхой бус байдал үүсэх нөхцөл бүрдэж байна. Иймд хуулийн төсөл нь өмчийн эрхийн хамгаалалт, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрх, шударга өрсөлдөөний суурь зарчмыг тогтоож, эдийн засгийн харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомжийг тайлбарлах, хэрэглэхэд баримтлах нийтлэг чиг баримжааг бүрдүүлэхэд чиглэж байна. Ингэснээр хууль тогтоомжийн хэрэглээний нэгдмэл байдал хангагдаж, шүүх болон захиргааны байгууллагын шийдвэрийн урьдчилан таамаглах боломж нэмэгдэн, эрх зүйн орчны тогтвортой байдал бэхжинэ.

Эцэст нь дүгнэхэд, энэхүү хуулийн төслийг боловсруулах үндэслэл нь Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан эдийн засгийн эрх, эрх чөлөө, өмчийн эрхийн хамгаалалт, хуулийн засаглалын зарчмыг бодитой хэрэгжүүлэх шаардлагаас урган гарч байна. Хуулийн төсөл нь эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийн уялдаа холбоог бэхжүүлэх, эдийн засгийн эрх чөлөөний эрх зүйн баталгааг тодорхой болгох, төрөөс эдийн засгийг зохицуулах эрх хэмжээ, хязгаарыг илүү тодорхой тогтоох замаар эрх зүйн орчны тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байдлыг хангахад чиглэж байна. Иймээс энэхүү хуулийн төсөл нь Үндсэн хуулийн үзэл санаа, эрх зүйн тогтолцооны хөгжлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн суурь шинжтэй зохицуулалт болно.

Олон улсын нэр хүндтэй судалгааны байгууллагуудын үнэлгээ Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний орчинд бодит сорилтууд байгааг харуулж байна. АНУ-ын Heritage Foundation байгууллагын 2025 оны Эдийн засгийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 62.6 оноо авч, 184 орноос 74 дүгээр байрт эрэмбэлэгдэн “дунд зэргийн эрх чөлөөтэй” ангилалд багтсан бол Канадын Fraser Institute байгууллагын Дэлхийн эдийн засгийн эрх чөлөөний тайланд 165 орноос 69 дүгээр байрт эрэмбэлэгдсэн байна. Аль аль судалгаанд өмчийн эрхийн хамгаалалт, хууль эрх зүйн орчны чанар, төрийн зохицуулалтын үр нөлөө харьцангуй сул үнэлэгдсэн нь Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг хязгаарлаж буй гол хүчин зүйлсийн нэг болохыг харуулж байна. Иймд эдийн засгийн эрх чөлөөний эрх зүйн баталгааг бэхжүүлэх, өмчийн эрх, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрхийн хамгаалалтыг сайжруулах, хууль тогтоомжийн тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой орчныг бүрдүүлэх шаардлага бодитоор тулгарч байна. Энэхүү хуулийн

төсөл нь дээрх суурь асуудлуудыг шийдвэрлэх, Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилготой болно.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

2.1. Хуулийн төслийн зорилго

Монгол Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан эдийн засгийн эрх, эрх чөлөөний агуулга, баталгааг тодорхойлж, өмчийн эрх, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрх, шударга өрсөлдөөний зарчмыг хамгаалах, эдийн засгийн харилцаанд төрөөс оролцох эрх хэмжээ, хязгаарыг тогтоох, улмаар тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой, өрсөлдөх чадвартай эдийн засгийн эрх зүйн орчныг бүрдүүлэхэд оршино.

2.2. Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Нэгдүгээрт, аж ахуй эрхлэгч болон төрийн байгууллагын хооронд үүсэх эдийн засгийн харилцааг зохицуулна. Энэ хүрээнд өмчийн эрх, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрх болон эдийн засгийн бусад эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхэд төрөөс мөрдөх зарчим, хязгаарлалт, үүргийг тодорхойлж, эдгээр эрхийг хязгаарлах нөхцөл, шаардлагыг тогтооно.

Хоёрдугаарт, эдийн засгийн харилцаанд оролцогч хоорондын харилцаанд баримтлах суурь зарчмыг тогтооно. Үүнд өмчийн эрхийг хүндэтгэх, гэрээний эрх чөлөөг хангах, шударга өрсөлдөөнийг хамгаалах, ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг эдийн засгийн эрх чөлөөний үндсэн зарчмууд хамаарна.

Гуравдугаарт, эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг тайлбарлах, хэрэглэхэд баримтлах суурь зарчим, чиг баримжааг тогтооно. Хуулийн төсөл нь эдийн засгийн эрх чөлөөний агуулга, төрийн зохицуулалтын хүрээ, өмчийн эрхийн хамгаалалт, өрсөлдөөний тэгш нөхцөл зэрэг нийтлэг зарчмыг тодорхойлсноор эдийн засгийн хууль тогтоомжийн нэгдмэл хэрэглээг хангахад чиглэнэ.

2.3. Хуулийн төслийн ерөнхий бүтэц

Хуулийн төсөл нь таван бүлэг, арван есөн зүйлээс бүрдэх бөгөөд дараах бүтэцтэй байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ (1-4 дүгээр зүйл)

Хуулийн зорилго, зарчим, хамрах хүрээ, бусад хууль тогтоомжтой харилцах харилцаа болон нэр томъёоны тодорхойлолтыг тусгасан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ (5 дугаар зүйл)

Эдийн засгийн эрх чөлөөний агуулга, өмчийн эрх, хөдөлмөрийн үр шимээ хүртэх эрх, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрх, шударга өрсөлдөөн, мөнгө, санхүү болон мэдээллийн халдашгүй байдлын үндсэн баталгааг тодорхойлж, эдгээр эрхийг хязгаарлах нийтлэг шалгуурыг тогтоосон.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ХЭЛБЭР (6-13 дугаар зүйл)

Өмчийн эрх, татвар, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх үйл ажиллагаа, өрсөлдөөний орчин, мөнгө, санхүүгийн харилцаа болон мэдээллийн хамгаалалтын хүрээнд төрөөс баримтлах зарчим, эрх хэмжээ, хязгаарлалтыг тодорхойлсон.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА, ШҮҮХИЙН ХАМГААЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ (14-16 дугаар зүйл)

Эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд төрийн хүлээх хариуцлага, учруулсан хохирлыг нөхөн төлөх журам, шүүхийн хамгаалалтын механизм, түүнчлэн хуулийн хэрэгжилтэд тавих ил тод байдал, хяналтын зохицуулалтыг тусгасан.

ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ НИЙЦҮҮЛЭХ, ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ (17-19 дүгээр зүйл)

Хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой шилжилтийн зохицуулалт, бусад хууль тогтоомжийг нийцүүлэх асуудал болон хууль хүчин төгөлдөр болох хугацааг тусгасан.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Энэхүү хуулийн төсөл хэрэгжсэнээр эдийн засгийн эрх чөлөөний эрх зүйн баталгаа бэхжиж, өмчийн эрхийн хамгаалалт, гэрээний эрх чөлөө, аж ахуй эрхлэх эрх, шударга өрсөлдөөний орчны тогтвортой байдал дээшилнэ. Үүний үр дүнд эдийн засгийн харилцаанд оролцогчдын хууль ёсны хүлээлт хамгаалагдаж, хөрөнгө оруулалтын орчны тодорхой байдал нэмэгдэн, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл бэхжинэ. Түүнчлэн төрийн зохицуулалтын ил тод байдал, хариуцлага сайжирч, зах зээлд нэвтрэхэд учирч буй зохицуулалтын саад тотгор буурснаар шударга өрсөлдөөн дэмжигдэж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа өргөжих таатай нөхцөл бүрдэнэ. Эдийн засгийн үйл ажиллагаа идэвхжиж, албан ёсны эдийн засгийн оролцоо нэмэгдэхийн хэрээр татварын суурь тэлж, төсвийн орлогын тогтвортой байдал сайжрахын зэрэгцээ ажлын байр, бүтээмж, иргэдийн орлогыг нэмэгдүүлэх урт хугацааны эерэг үр нөлөө бий болно. Ийнхүү хуулийн төсөл нь эдийн засгийн эрх чөлөөг бэхжүүлэх замаар тогтвортой өсөлт, өрсөлдөх чадвар, хувийн хэвшилд тулгуурласан эдийн засгийн хөгжлийг дэмжих эрх зүйн суурийг бүрдүүлнэ.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай хэрхэн уялдах талаарх санал

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хууль тогтоомжийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Эдийн засгийн эрх чөлөөний тухай”
Хуулийн төслийн тухай

Нэг. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа:

Монгол Улсын Үндсэн хууль нь “хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм”-ийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгосон. Энэхүү эрхэм зорилгын эдийн засгийн үндэс нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь ... хувийн өмчид тулгуурласан ... олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “... хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хувийн өмчлөх”, 4 дэх хэсэгт “...ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй” гэж тус тус тунхаглан баталгаажуулсан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн эдгээр заалт нь хувийн өмч, хувийн санаачилга, шударга өрсөлдөөнд тулгуурласан зах зээлийн эдийн засгийн тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоосон билээ. Гэвч эдгээр үндсэн зарчмыг хэрэгжүүлэх, бодит агуулгаар хангах үүрэг бүхий хууль тогтоомж нь сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд салангид байдлаар хөгжиж, эдийн засгийн эрх чөлөөг хамгаалах нэгдмэл үзэл баримтлал, суурь зарчим хангалттай бүрдээгүй байна. Үүний улмаас Үндсэн хуульд тунхагласан эдийн засгийн эрх, эрх чөлөөний баталгаа болон түүний бодит хэрэгжилтийн хооронд тодорхой зөрүү үүсэж, эдийн засгийн харилцаанд эрх зүйн тогтвортой байдал, урьдчилан таамаглах боломж, төрийн хэт их оролцоо, төрийн өмчит компаниудын давамгайлалтай байдалтай холбоотой бодит хүндрэлүүд бий болжээ.

“Эдийн засгийн эрх чөлөөний тухай” хуулийн төсөл нь Үндсэн хуулийн үзэл санааг өдөр тутмын харилцаанд хэрэгжүүлэх, эдийн засгийн эрх чөлөөнд ямар тохиолдолд хязгаарлалт тогтоож болох, түүнийг хэрхэн хамгаалах зэрэг нарийвчилсан механизмыг бий болгох зорилготой ерөнхий хууль юм.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт, бүтээмж, хувийн хэвшлийн хөгжлийн үндэс нь эдийн засгийн эрх чөлөө, өмчийн эрхийн баталгаа, гэрээний тогтвортой байдал, шударга өрсөлдөөн юм. Иймд хүний эдийн засгийн суурь эрх, эрх чөлөөг хамгаалах, төрөөс эдийн засгийг зохицуулах үйл ажиллагааны зорилго, хэлбэр, хязгаарыг тодорхой болгох, эдийн засгийн харилцаанд эрх зүйн тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой орчныг бүрдүүлэх, төр болон хувийн хэвшлийн харилцаанд хариуцлага, ил тод байдлыг бэхжүүлэх зорилгоор Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Хоёр: Зарчмын шинжтэй зохицуулалт

Хуулийн төсөл нь эдийн засгийн харилцааны эрх зүйн суурийг цэгцлэх, Үндсэн хуулийн зарчмыг бодит агуулгаар баталгаажуулах хүрээнд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

1. Хууль ёсоор олж авсан өмчийн халдашгүй, дархан байдлыг баталгаажуулж, түүнд зөвхөн нийтийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, шүүхийн шийдвэр, зах зээлийн бодит үнээр урьдчилан олгосон нөхөн олговортойгоор халдах нарийвчилсан журмыг тогтоосон;

2. Иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан татварын болон бусад хууль тогтоомжийг буцаан хэрэглэхийг хориглож, эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах;
3. Талууд сайн дурын үндсэн дээр байгуулсан гэрээний эрх чөлөөг төр хүндэтгэх бөгөөд түүний биелэлтийг шударга, хараат бус шүүхээр хамгаалах баталгааг бий болгосон;
4. Хуулиар хориглоогүй аливаа аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрхийг баталгаажуулж, шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх үүргийг төрд хүлээлгэсэн;
5. Энэхүү хуульд заасан эдийн засгийн суурь эрхийг зөвхөн Үндсэн хуульд заасан нийтийн эрх ашгийн үүднээс, зөвхөн хуулиар, зайлшгүй шаардлагатай, хамгийн бага хэмжээнд хязгаарлах зарчмыг тодорхойлсон

Гурав. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал

Монгол Улсад эдийн засгийн эрх чөлөө, хувийн өмчийн хамгаалалт, бизнес эрхлэх орчны асуудлыг бие даасан нэг хууль бус, харин Үндсэн хууль болон салбарын олон хууль, бодлогын баримт бичгээр хэсэгчлэн зохицуулж ирсэн байна.

1990 оны ардчилсан өөрчлөлтөөс хойш Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор эдийн засгийн эрх чөлөөний суурь зарчмуудыг хуульчлан тогтоох үйл явц эхэлсэн.

Ийнхүү эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой харилцааг Монгол Улсад өмнө нь: Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль зэрэг салангид олон хуулиар зохицуулж ирсэн боловч эдгээрийг нэгтгэн:

Дөрөв. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагч нь эдийн засгийн эрх чөлөөний талаарх олон улсын туршлага, Монгол Улсын өнөөгийн эрх зүйн орчин, бизнесийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг судлан шинжилж, холбогдох судалгаа, хэлэлцүүлэг, санал авах ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулсан.

Тухайлбал:

- Монгол Улсын Үндсэн хууль болон эдийн засаг, хөрөнгө оруулалт, өрсөлдөөн, зөвшөөрөл, татвар, өмчийн эрхтэй холбоотой хүчин төгөлдөр хууль тогтоомжид дүн шинжилгээ хийсэн;
- Эдийн засгийн эрх чөлөөний чиглэлээр Сингапур, Шинэ Зеланд, Эстони, Гүрж зэрэг улсын эрх зүйн орчин, бодлогын туршлагыг харьцуулан судалсан;
- Бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, эдийн засагчид, хуульчид, судлаачдын санал, байр суурийг сонсох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан;

- Төрийн байгууллагуудаас олгодог зөвшөөрөл, лицензийн тоо, давхардал, бизнесийн үйл ажиллагаанд үзүүлж буй нөлөөлөлд судалгаа хийсэн;
- Төрийн өмчит аж ахуйн нэгжийн эдийн засаг дахь оролцоо, өрсөлдөөний орчинд үзүүлж буй нөлөөлөлд дүн шинжилгээ хийсэн;
- Хөрөнгө оруулалтын орчин, хувийн өмчийн хамгаалалт, шүүхийн үр нөлөө, бизнесийн орчны талаарх олон улсын индекс, тайлан, судалгааны мэдээллийг ашигласан;
- Хуулийн төслийн үзэл баримтлал, зохицуулалтын үр нөлөөний үнэлгээг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авсан;
- Хуулийн төсөлтэй холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг судалж, уялдаа холбоог хангах чиглэлээр ажилласан.

Ийнхүү хуулийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн эрх чөлөөг хангах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрийн оролцоог оновчтой болгох, хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно.

Тав. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн

Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн төслийг боловсруулах хүрээнд хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, бизнесийн байгууллагуудын төлөөлөлтэй 2 удаагийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, төслийн үзэл баримтлал болон зохицуулалтын талаар санал авч ажилласан байна.

Хэлэлцүүлэгт:

- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн байгууллагуудын дунд 2026 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр МҮХАҮТ-д зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт танхимын 20 гаруй гишүүн байгууллагын төлөөлөл оролцож санал бодлоо илэрхийлсэн.
- Монголын Бизнесийн зөвлөлийн гишүүн байгууллагуудын дунд 2026 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан бөгөөд Монголын Бизнесийн зөвлөлийн 2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 26/14 дугаар албан бичгээр холбогдох саналаа албажуулан ирүүлсэн.

Хэлэлцүүлгийн үеэр дараах үндсэн асуудлуудаар санал төвлөрсөн байна. Үүнд:

- хувийн өмч болон хөрөнгийн эрхийн халдашгүй байдлыг баталгаажуулах;
- төрөөс өмч дайчлан авах нөхцөл, журмыг тодорхой болгох;
- нөхөх олговрыг шударга зах зээлийн үнэлгээнд тулгуурлан тогтоох;
- төр аж ахуй эрхлэгчтэй өрсөлдөхийг хязгаарлах;
- зөвшөөрөл, лицензийн тогтолцоог хялбаршуулах;
- төрийн байгууллагын шийдвэрийн улмаас бизнесийн үйл ажиллагааг үндэслэлгүйгээр хязгаарлахгүй байх;
- эдийн засгийн эрх чөлөөтэй холбоотой зарчмуудыг бусад салбарын хуультай уялдуулах;
- аж ахуй эрхлэгчийн хууль ёсны хүлээлт, бизнесийн нэр хүндийг хамгаалах;
- төрийн зохицуулалтын тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой орчныг бүрдүүлэх асуудлууд байв.

Зургаа. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт.

“Эдийн засгийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэж буй, эдийн засгийн шилжилтийг амжилттай хийсэн зарим улс орны Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг судалсан. Уг судалдгаанд Эстони Улсын Үндсэн хууль, Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хууль, Бүгд Найрамдах Чили Улсын Үндсэн хууль, Ирланд Улсын Үндсэн хуулийг тус тус судалсан. Төр нь хувийн өмчийн эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрх нь нийгмийн шударга ёсны дагуу, нийтийн сайн сайхны төлөө зарчимд нийцүүлэн төрөөс зохицуулагдах болно.

- **2.** Иймээс Төр нь хувийн өмчийн эрхийг хэрэгжүүлэхэд нийтийн сайн сайхны төлөө шаардлагаар хязгаарлалт тогтоож болно. ... Аливаа өмчийг хууль бусаар хураахыг хориглоно.

(Энэхүү хавсралтад бусад улсын холбогдох хуулийн заалтыг нэмж оруулах боломжтой)

Монгол Улсын эдийн засгийн орчны бодит байдлыг оношлохдоо бид АНУ-ын “Heritage Foundation”-ийн 1995 оноос хойш жил бүр эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн түүхэн мэдээлэл, Канадын “Fraser Institute”-ийн “Дэлхийн эдийн засгийн эрх чөлөө” тайлан, “Transparency International” байгууллагын “Авлигын төсөөллийн индекс”, “World Justice Project”-ийн “Хууль дээдлэх ёсны индекс” зэрэг олон улсын харьцуулсан, стандартчилагдсан үнэлгээнүүдэд гүнзгий дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банкны Монгол Улсын эдийн засаг, засаглалын талаарх үеийн тайлан, зөвлөмжүүд, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас эрхлэн гаргадаг “Бизнесийн итгэлийн индекс”, Үндэсний Статистикийн Хорооны макро эдийн засгийн болон нийгмийн үзүүлэлтүүдийг ашиглан асуудлыг дотоодын нөхцөл байдалтай нягт уялдуулсан. Онолын болон философийн үндэслэлийг боловсруулахдаа бид эдийн засгийн шинжлэх ухаанд Нобелийн шагнал хүртсэн Дуглас Норт, Фридрих фон Хайек, Милтон Фридман зэрэг сэтгэгчдийн институцийн эдийн засаг, эрх чөлөөт нийгмийн талаарх сонгодог бүтээлүүдээс эш татаж, харьцуулсан эрх зүйн шинжилгээ хийхдээ Эстони, Польш, Чили, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг эдийн засгийн шилжилтийг амжилттай хийсэн орнуудын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжийн түүхэн туршлагыг нарийвчлан судалсан болно.

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөө, төр нь өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах зарчимд тулгуурлан хувь хүний эдийн засгийн суурь эрх, эрх чөлөөг хуульчлан баталгаажуулах, хувийн өмчийн эрх, гэрээний эрх чөлөө, хөдөлмөр ба хөрөнгө оруулалтын үр шимийг хамгаалах, шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог хязгаарлах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтвортой орчныг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

-oOOo-

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

“Эдийн засгийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийн тухай

Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх эрхэм зорилгын эдийн засгийн бодит агуулгыг бүрдүүлэх, улс орныг сүүлийн гучаад жилийн турш нэрвээд буй эдийн засгийн зогсонги байдал, институцийн доройтлын гүнзгий, системийн шинжтэй гажуудлаас ангижруулах зорилгоор боловсруулсан “Эдийн засгийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, түүний зүйл, заалт тус бүрийн цаад шалтгаан, онол-философийн үндэслэл, хэрэгжсэнээр бий болох нийгэм, эдийн засгийн үр дагаврыг шинжлэх ухааны нотолгоонд тулгуурлан, олон талаас нь, иж бүрнээр тайлбарлах зорилготой болно. Энэхүү баримт бичиг нь зөвхөн хуулийн төсөлд хийж буй техник шинжтэй тайлбар бус, харин Монгол Улсын хөгжлийн парадигмыг өөрчлөх, хувийн хэвшлийн санаачилга, шударга өрсөлдөөнд суурилсан, дэлхийн жишигт нийцсэн, өрсөлдөх чадвартай эдийн засгийн тогтолцооны эрх зүйн суурийг тавих стратегийн ач холбогдол бүхий шинэчлэлийн шинжлэх ухааны үндэслэлийг цогцоор нь танилцуулж, Улсын Их Хурал, Засгийн газар болон нийт ард иргэдийг мэдээлэлд суурилсан, алсын хараатай, түүхэн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд түүний гол ач холбогдол оршино.

Бид энэхүү хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулахдаа олон талт, цогц арга зүйг ашигласан бөгөөд мэдээллийн эх сурвалжийн хувьд дэлхийн нэр хүнд бүхий судалгааны байгууллагууд, санхүүгийн институциуд, эрдэмтэн мэргэдийн сүүлийн хориос доошгүй жилийн хугацааны өргөн хүрээтэй мэдээллийн санг ашигласан болно. Тухайлбал, Монгол Улсын эдийн засгийн орчны бодит байдлыг оношлохдоо бид АНУ-ын “Heritage Foundation”-ийн 1995 оноос хойш жил бүр эрхлэн гаргадаг “Эдийн засгийн эрх чөлөөний индекс”-ийн түүхэн мэдээлэл, Канадын “Fraser Institute”-ийн “Дэлхийн эдийн засгийн эрх чөлөө” тайлан, “Transparency International” байгууллагын “Авлигын төсөөллийн индекс”, “World Justice Project”-ийн “Хууль дээдлэх ёсны индекс” зэрэг олон улсын харьцуулсан, стандартчиглагдсан үнэлгээнүүдэд гүнзгий дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банкны Монгол Улсын эдийн засаг, засаглалын талаарх үе үеийн тайлан, зөвлөмжүүд, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас эрхлэн гаргадаг “Бизнесийн итгэлийн индекс”, Үндэсний Статистикийн Хорооны макро эдийн засгийн болон нийгмийн үзүүлэлтүүдийг ашиглан асуудлыг дотоодын нөхцөл байдалтай нягт уялдуулсан. Харьцуулсан эрх зүйн шинжилгээ хийхдээ Эстони, Польш, Чили, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг эдийн засгийн шилжилтийг амжилттай хийсэн орнуудын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжийн түүхэн туршлагыг нарийвчлан судалсан болно.

Эрх чөлөөний үзүүлэлтээр Heritage Foundation-ийн индексээр 62.6 оноо авч дэлхийн 184 орноос 74-т, Fraser Institute-ийн үнэлгээгээр 6.86 оноо авч 165 орноос 69-т эрэмбэлэгдэн, “дунд зэргийн эрх чөлөөтэй” гэсэн ангилалд сүүлийн арваад жилийн турш дорвитой ахиц гаргалгүй гацсан энэхүү зогсонги байдал нь зүгээр нэг тоон үзүүлэлт бус, харин эдийн засагчдын нэрлэдгээр “дундаж орлогын хавх”-нд орох бодит эрсдэлийн тод илрэл мөн юм. Энэхүү хавхны гол шалтгаан нь түүхий эдийн салбараас хэт хамааралтай, төрөлжиж чадаагүй эдийн засгийн бүтэц, түүнийг дагалдан бий болсон, төрийн үйл ажиллагааны шударга байдал

(Transparency International-ийн индексээр 33/100), өмчийн эрхийн хамгаалалт (Heritage Foundation-ийн индексээр 49/100), хөрөнгө оруулалтын орчны таагүй байдал (Heritage Foundation-ийн индексээр 50/100) зэрэг институцийн архагшсан, системийн шинжтэй гажуудал болох нь бидний хийсэн шинжилгээгээр бүрэн тогтоогдсон. Иймд, эдгээр суурь, бүтцийн шинжтэй асуудлыг шийдвэрлэхгүйгээр, зөвхөн салбарын явцуу хүрээний, хэсэгчилсэн “нөхөөс” хийх төдий арга хэмжээ авах нь цаг хугацаа алдаж, улс орныг урт хугацааны хөгжлийн зогсонги байдалд хүргэх нь гарцаагүй юм.

Хүснэгт 2: Эдийн засгийн эрх чөлөөний түвшин ба Нэг хүнд ногдох ДНБ (2024 оны тайлан, 2022 оны мэдээлэл)

Эдийн засгийн эрх чөлөөний ангилал	Нэг хүнд ногдох ДНБ (ам.доллар, ХАЧТ*)
Эрх чөлөөтэй (Free)	\$103,869
Ихэнхдээ эрх чөлөөтэй (Mostly Free)	\$61,052
Дунд зэргийн эрх чөлөөтэй (Moderately Free) (Монгол Улс энэ ангилалд багтдаг)	\$32,225
Ихэнхдээ эрх чөлөөгүй (Mostly Unfree)	\$10,637
Дарангуйлалтай (Repressed)	\$10,389

*ХАЧТ - Худалдан авах чадварын тэнцвэр

Эх сурвалж: The Heritage Foundation, "Highlights of the 2024 Index of Economic Freedom", хуудас 8, Chart 1.

Хүснэгт 3: Монгол Улсын Эдийн засгийн эрх чөлөөний индексийн зарим дэд үзүүлэлтийн харьцуулсан шинжилгээ (2025 он)

Үзүүлэлт (100-аас)	Монгол Улсын оноо	Дэлхийн дундаж	Эстони (8-р байр)	Үнэлгээний тайлбар
ЕРӨНХИЙ ОНОО	62.6	58.6	78.0	Дунд зэргийн эрх чөлөөтэй, савлагаатай
I. Хууль дээдлэх ёс				
Өмчийн эрхийн хамгаалалт	49.0	53.6	89.1	Сул
Шүүхийн үр нөлөө	45.1	51.5	80.2	Сул
Төрийн үйл ажиллагааны шударга байдал	35.0	42.1	76.0	Маш сул
II. Зохицуулалтын үр ашиг				
Бизнесийн эрх чөлөө	68.0	63.8	84.9	Харьцангуй сайн
III. Зах зээлийн нээлттэй байдал				

Хөрөнгө оруулалтын эрх чөлөө	50.0	58.1	80.0	Хязгаарлагдмал
Санхүүгийн эрх чөлөө	50.0	48.7	70.0	Хязгаарлагдмал

Эх сурвалж: Heritage Foundation, "2025 Index of Economic Freedom" тайланд хийсэн шинжилгээ.

Энэхүү хүснэгтээс харахад, Монгол Улсын хувьд "Хууль дээдлэх ёс" хэмээх эдийн засгийн бүх тогтолцооны суурь болсон тулгуур багана бүхэлдээ нурж унасан дүр зураг ажиглагдаж байна. Ялангуяа, "Төрийн үйл ажиллагааны шударга байдал" буюу авлигын эсрэг үзүүлэлт 35.0 оноотой байгаа нь зөвхөн дэлхийн дунджаас доогуур төдийгүй, "дарангуйлалтай" орнуудын жишигт ойрхон, сүйрлийн хэмжээний үнэлгээ юм. Энэ нь төрийн шийдвэр гаргалт, хуулийн хэрэгжилтэд системийн шинжтэй авлига гүнзгий нэвтэрч, шударга өрсөлдөөнийг устгаж, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төрд итгэх итгэлийг бүрэн алдагдуулсныг илтгэнэ. Үүнтэй нягт уялдаатайгаар "Өмчийн эрхийн хамгаалалт" 49.0, "Шүүхийн үр нөлөө" 45.1 гэсэн оноонууд нь иргэдийн хөдөлмөрлөж олсон хөрөнгө нь хуулиар найдвартай хамгаалагдаж чадахгүй, маргаан гарсан тохиолдолд шүүхээр шударга, шуурхай шийдвэрлүүлж чадна гэдэгтээ итгэлгүй байгаагийн тоон илэрхийлэл юм. Энэхүү ухралт, доройтол нь биднийг зүгээр нэг зогсонги байдалд бус, харин хөгжлийн буруу зам руу хөтөлж байгаа тул, энэ чиг хандлагыг нэн даруй эргүүлж, улс орны хөгжлийн жолоог зөв замд нь оруулахын тулд эдгээр бүх асуудлын уг шалтгаан болсон суурь зарчмыг хуульчлан тогтоох системийн цогц шинэчлэл хийх нь гарцаагүй бөгөөд зайлшгүй шаардлагатай болоод байна.

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлгийн нэгдүгээр зүйлд энэ хуулийн зохицуулалт, зорилтыг, хоёрдугаар зүйлд эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг, гуравдугаар зүйлд хуулийн үйлчлэх хүрээг, дөрөвдүгээр зүйлд хуульд дурдагдсан тайлбарлах шаардлагатай нэр томъёоны тодорхойлолтыг тус тус тусгалаа.

Зарим нэг нэр томъёог тайлбарлахдаа "аж ахуй эрхлэгч" гэж Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.3-т заасанчлан Монгол Улсад бүртгэлтэй, аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг гэж ойлгоно.

Хуулийн төсөлд хэрэглэсэн "аж ахуйн нэгж" гэсэн нэр томъёог Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.1-д заасан тодорхойлолттой нийцүүлэн хэрэглэсэн болно. Ингэснээр Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжид хэрэглэж байгаа нэр томъёоны нэгдмэл байдлыг хангах зорилготой.

"Аж ахуйн үйл ажиллагаа" гэсэн ойлголтыг бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх болон түүнтэй адилтгах эдийн засгийн үйл ажиллагааг хамруулах утгаар хэрэглэсэн бөгөөд энэ нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид хэрэглэгдэж байгаа агуулгатай нийцэж байна.

"Шударга өрсөлдөөн" гэсэн нэр томъёог Өрсөлдөөний тухай хуульд тусгагдсан чөлөөт, тэгш боломж бүхий зах зээлийн өрсөлдөөний зарчимд үндэслэн тодорхойлсон бөгөөд аж ахуй эрхлэгчид ялгаварлалгүй, тэгш нөхцөлд зах зээлд оролцох боломжийг илэрхийлэх утгаар хэрэглэсэн.

“Эдийн засгийг зохицуулах” гэсэн ойлголтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан төрийн эдийн засгийг зохицуулах чиг үүргийн агуулгад тулгуурлан хэрэглэсэн бөгөөд төрөөс үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгоор эдийн засгийн харилцаанд хууль тогтоомжийн хүрээнд нөлөөлөх үйл ажиллагааг ойлгоно.

Хуулийн төсөлд хэрэглэсэн нэр томъёо, ухагдахууныг Монгол Улсын Үндсэн хууль болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль тогтоомжид хэрэглэж байгаа нэр томъёотой нийцүүлэн боловсруулсан болно.

Хоёрдугаар бүлэг буюу эдийн засгийн эрх чөлөө бүлгийн тавдугаар зүйлд аж ахуй эрхлэгчийн эрх, эрх чөлөөг зааж өгсөн бөгөөд энэхүү суурь эрх, эрх чөлөөг зайлшгүй тохиолдолд хязгаарлахдаа баримтлах шаардлагыг зааж өгсөн.

Гуравдугаар бүлэг буюу Эдийн засгийн эрх чөлөөний баталгаа бүлгийн зургадугаар зүйлд Төрийн эдийн засгийн зохицуулалт, харилцааны хүрээ, арга хэлбэрийн хязгаарыг тогтоож өглөө. Долдугаар зүйлд өмчлөх эрхийн баталгаа нь өмчлөх эрхийн халдашгүй, дархан байдлыг баталгаажуулсан хэм хэмжээ нь энэхүү хуулийн төдийгүй, аливаа чөлөөт, зах зээлийн эдийн засгийн тогтолцооны жинхэнэ утга учир, суурь тулгын чулуу нь болж өгдөг билээ. Тус зүйлд хувь хүний өмчийг зөвхөн нийтийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн, шүүхийн шийдвэрээр, урьдчилан, зах зээлийн бодит үнээр нөхөн олговор олгосны үндсэн дээр л дайчлан авч болохыг маш тодорхой, маргаангүйгээр зааж өгсөн нь өнөөдрийг хүртэл төрийн байгууллагын зүгээс “нийтийн хэрэгцээ” гэсэн тодорхойгүй ойлголтоор далимдуулан иргэд, аж ахуйн нэгжийн өмчийг дур зоргоороо, шударга бусаар авах, эсвэл үнэгүйдүүлэх боломжийг олгож байсан эрх зүйн цоорхойг бүрэн хааж, төрийн дур зоргыг хуулиар хязгаарлаж буй түүхэн ач холбогдолтой алхам юм. Энэхүү эрх зүйн баталгаа нь дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн том айдас, эргэлзээ болдог улс төрийн эрсдэл, эрх зүйн орчны тодорхойгүй байдлыг эрс бууруулснаар, тэдний Монгол Улсын эдийн засгийн ирээдүйд итгэх итгэлийг сэргээх хамгийн хүчтэй хөшүүрэг болох бөгөөд үүний үр дүнд хувь хүмүүс, аж ахуйн нэгжүүд зөвхөн богино хугацааны, хурдан ашиг олохыг эрмэлзэх бус, харин урт хугацааны, тогтвортой, бүтээмж өндөртэй хөрөнгө оруулалт хийх, капиталын хуримтлал үүсгэх эдийн засгийн суурь нөхцөл бүрдэнэ. Цаашлаад, өмчийн эрхийн баталгаажилт нь санхүүгийн зах зээлийн хөгжилд шууд нөлөөлж, үл хөдлөх хөрөнгийн барьцаалах чадварыг нэмэгдүүлэн, зээлийн хүртээмжийг сайжруулж, нийт эдийн засгийн “цусны эргэлт”-ийг эрүүлжүүлэх нийгэм, эдийн засгийн асар их эерэг үр дагаврыг авчрах болно.

Наймдугаар зүйл. Тус зүйлийн 8.1 дахь хэсэгт “Татварын хууль тогтоомжийг иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан байдлаар буцаан хэрэглэхийг хориглоно” гэж заасан нь бидний урьдчилан тандан судлах тайланд онцолсон Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны хамгийн том сул тал болох эрх зүйн орчны тогтворгүй байдал, “тоглоомын дүрмийг дундаас нь өөрчилдөг” гэсэн сөрөг ойлголтыг арилгахад чиглэсэн шууд, тодорхой арга хэмжээ юм. Энэхүү заалт нь бодит амьдрал дээрх гашуун туршлагаас урган гарсан бөгөөд ирээдүйд үүсэж болзошгүй их хэмжээний татварын маргаан, олон улсын арбитрын заргаас урьдчилан сэргийлж, улс орны эдийн засгийг асар их зардал, нэр хүндийн хохирлоос хамгаалах стратегийн ач холбогдолтой юм. Энэхүү баталгаа нь бизнес эрхлэгчдэд урт хугацааны төлөвлөлт хийх, ирээдүйн ашиг, орлогоо бодитойгоор тооцоолох, улмаар шинээр хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх

шийдвэрийг итгэлтэйгээр гаргах нөхцөлийг бүрдүүлснээр, эдийн засгийн өсөлтийг дорвитой дэмжих болно.

Хүснэгт 1: Татварын орчны тогтвортой байдлын үр нөлөөний харьцуулсан үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Одоогийн байдал (Хууль батлагдаагүй нөхцөлд)	Хууль батлагдсаны дараах нөхцөл
Тогтвортой байдал	Сул, урьдчилан таамаглахад хүндрэлтэй. Улс төрийн мөчлөгөөс хамааран татварын хууль тогтоомж байнга өөрчлөгдөх, буцаан хэрэглэгдэх эрсдэлтэй.	Өндөр, урьдчилан таамаглахуйц. Хуулийн заалтаар тогтвортой байдал баталгаажиж, буцаан хэрэглэх эрсдэл арилна.
Хөрөнгө оруулагчийн эрсдэл	Маш өндөр. Эрх зүйн эрсдэл нь хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцоолох боломжгүй болгож, шинэ хөрөнгө оруулалтыг үргээдэг.	Эрс буурна. Эрх зүйн орчны найдвартай байдал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад эерэгээр нөлөөлж, капиталын урсгалыг дэмжинэ.
Төрийн үүрэг	Тодорхойгүй, зарим тохиолдолд дур зоргын шинжтэй. Төрийн байгууллага хуулийг өргөжүүлэн тайлбарлах, дарамт учруулах боломжтой.	Тодорхой, хуулиар хязгаарлагдсан. Төрийн үүрэг нь зөвхөн хуулийг нэг мөр, шударгаар хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

Энэхүү зохицуулалтын үр дүнд, “Heritage Foundation”-ийн “Татварын дарамт” (Tax Burden) болон “Төсвийн эрүүл мэнд” (Fiscal Health) гэсэн үзүүлэлтүүд дунд болон урт хугацаандаа эерэгээр үнэлэгдэх бөгөөд хамгийн чухал нь, төр ба хувийн хэвшлийн хоорондын итгэлцэл сэргэж, эдийн засгийн харилцаа илүү эрүүл, бүтээмжтэй болох суурь нөхцөл бүрдэх юм. Энэ бол зөвхөн хөрөнгө оруулагчдад хамаатай асуудал бус, харин өөрийн хөдөлмөрийн үр шимээрээ амьдарч буй иргэн бүрийн хуримтлал, ирээдүйн баталгааг хамгаалж буй нийгмийн өргөн ач холбогдолтой зохицуулалт мөн.

Есдүгээр зүйл. Гэрээний эрх чөлөө: Хуулийн төслийн зургадугаар зүйлд тусгагдсан гэрээний эрх чөлөөний зарчим нь хувь хүний сонголт хийх, өөрийн амьдралыг өөрөө авч явах гэсэн либерал ардчилсан нийгмийн суурь үнэт зүйлийн эдийн засгийн харилцаан дахь хамгийн тод илрэл бөгөөд энэхүү хуулийн төслийн үзэл санааны нэгэн чухал бүрэлдэхүүн хэсэг мөн. Энэ зүйлд хувь хүн, хуулийн этгээд нь бусадтай сайн дурын үндсэн дээр, чөлөөтэй гэрээ байгуулах, гэрээнийхээ нөхцөлийг харилцан тохиролцож, өөрсдөө тодорхойлох эрхтэй гэдгийг баталгаажуулж, харин төрийн үүргийг энэхүү эрх чөлөөг хүндэтгэх, байгуулсан гэрээг шударга, хараат бус шүүхээр хамгаалах баталгааг хангах явдал гэж тодорхойлсон нь өнөөгийн практикт тулгарч буй олон бэрхшээлийг шийдвэрлэхэд чиглэгдсэн юм. Бодит байдал дээр, төр нь зарим тохиолдолд гэрээний харилцаанд шаардлагагүйгээр хөндлөнгөөс оролцох, тодорхой нэг талд давуу байдал олгох, эсвэл гэрээний маргаан үүссэн үед шүүхийн системийн удаан, хүнд сурталт ажиллагаанаас болж гэрээний үүргээ биелүүлээгүй тал нь хариуцлагаас зайлсхийх боломжтой болдог нь нийт эдийн засгийн харилцаанд үл итгэлцлийг бий болгож, “гүйлгээний зардал”-ыг эрс нэмэгдүүлж байдаг. Энэхүү зохицуулалт нь “Heritage Foundation”-ийн “Шүүхийн үр нөлөө” (Judicial Effectiveness) гэсэн үзүүлэлтийг

сайжруулахад шууд, эерэг нөлөө үзүүлэх бөгөөд гэрээ нь зөвхөн цаасан дээрх амлалт бус, харин бодитоор хэрэгждэг, хуулийн хүчээр хамгаалагдсан, найдвартай хэрэгсэл болох итгэлийг нийгэмд бий болгоно. Гэрээний эрх чөлөө баталгаатай болсон орчинд эдийн засгийн харилцаа илүү уян хатан, үр ашигтай болж, иргэд, аж ахуйн нэгжүүд ирээдүйдээ итгэлтэйгээр, урт хугацааны, нарийн төвөгтэй хэлцлүүдийг хийх зоригтой болсноор эдийн засгийн эргэлт хурдасч, хөгжил дэвшилд хүрэх нэгэн чухал нөхцөл бүрдэх юм.

Аравдугаар зүйл. Аж ахуй эрхлэх, чөлөөтэй өрсөлдөх эрх, Хуулийн төслийн долдугаар зүйлд тусгагдсан аж ахуй эрхлэх, чөлөөтэй өрсөлдөх эрхийг баталгаажуулсан хэм хэмжээ нь Монгол Улсын эдийн засгийн ирээдүйн өсөлтийн гол хөдөлгөгч хүч болох хувийн хэвшлийнхний санаачилгыг дэмжих, тэдний өмнө тулгарч буй зохицуулалтын болон институцийн саад тотгорыг арилгахад чиглэгдсэн, энэхүү шинэчлэлийн зүрхэн хэсэг болсон зохицуулалт юм. Энэ зүйлд “хуулиар хориглоогүй аливаа аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрхтэй” гэж тунхагласан нь өнөөг хүртэл ноёрхож ирсэн “төр зөвшөөрвөл хийнэ” гэсэн хүнд сурталт, патерналист сэтгэлгээнээс “хуулиар хориглоогүй л бол хийх нь иргэний суурь эрх” гэсэн эрх чөлөөт, хариуцлагатай иргэний нийгмийн сэтгэлгээнд шилжих парадигмын томоохон өөрчлөлтийг эрх зүйн хувьд баталгаажуулж буй хэрэг мөн. Энэхүү зарчим нь ирээдүйд төрийн байгууллагууд дур мэдэн, ямар ч бодитой үндэслэлгүйгээр шинээр зөвшөөрөл, лиценз, хориг, хязгаарлалт бий болгох боломжийг хааж, аливаа зохицуулалт нь нийтийн эрх ашигт зайлшгүй шаардлагатай гэдгээ нотлох үүргийг төрд хүлээлгэж байгаагаараа асар их ач холбогдолтой юм. Энэ нь бидний урьдчилан тандан судлах тайланд дурдсан, нэг аж ахуйн нэгжид жилд дунджаар 9 сая төгрөгийн дарамт учруулж буй “гүйлгээний зардал”-ыг бодитойгоор бууруулж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн нуруун дээрх ачааг хөнгөлснөөр, тэднийг өсөж, дэвжих, шинээр ажлын байр бий болгох бодит боломжийг нээж өгнө.

Арваннэг, Арванхоёр, Арвангурав дугаар зүйл. Хуулийн өмнө эрх тэгш байх, мөнгө, санхүү, мэдээллийн харилцаан дахь эрх чөлөө: Хуулийн төслийн найм, ес, аравдугаар зүйлүүдэд тусгагдсан хэм хэмжээнүүд нь тусдаа орших, явцуу хүрээний зохицуулалтууд мэт харагдаж болох ч, эдгээр нь эдийн засгийн эрх чөлөөний нийтлэг орчныг бүрдүүлэгч, өмнөх зүйлүүдэд заасан суурь эрхүүдийн бодит хэрэгжилтийг баталгаажуулагч, салшгүй, чухал бүрэлдэхүүн хэсгүүд юм. “Эдийн засгийн харилцаанд оролцогч бүр хуулийн өмнө эрх тэгш байна” гэж заасан нь Үндсэн хуулийн ардчилсан, эрх зүйт төрийн хамгийн гол зарчмыг эдийн засгийн харилцаанд тусгайлан баталгаажуулж, өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, дотоодын эсвэл гадаадын хөрөнгө оруулалттай эсэхээс үл хамааран, хууль нь бүх этгээдэд ялгаварлалгүйгээр, нэгэн адил үйлчлэх ёстой гэдгийг илэрхийлж байна. Энэ нь төрийн байгууллага, албан тушаалтан тодорхой нэг компанид давуу байдал олгох, эсвэл нөгөөг нь ялгаварлан гадуурхах, улс төрийн болон бизнесийн явцуу ашиг сонирхлоор хандах боломжийг хуулиар хязгаарлаж, шударга бус өрсөлдөөний нэгэн том үүд хаалгыг хааж буй хэрэг мөн.

Дөрөвдүгээр бүлэг буюу хариуцлага, шүүхийн хамгаалалт, ил тод байдал, хяналт бүлэгт төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлагын асуудлыг тусгаж өгсөн бөгөөд 15 дугаар зүйлд шүүхийн хамгаалалт буюу аж ахуй эрхлэгчийн эдийн засгийн эрх чөлөө зөрчигдсэн тохиолдолд төрийн байгууллага, шүүхэд хандан эрхээ хамгаалуулах, сэргээх баталгааг тогтоосон. Мөн эдийн засгийн эрх чөлөөг хязгаарласан төрийн шийдвэр, үйл ажиллагаа нь хуульд заасан шаардлагад нийцсэн болохыг төр өөрөө нотлох үүрэгтэй байхаар тусгасан.

Хуулийн төслийн арванзургадугаар зүйл, арвандолдугаар зүйлээр эдийн засгийн эрх чөлөөний хэрэгжилтэд тавих хяналт, тайлагналын тогтолцоог бүрдүүлж, Засгийн газрын хүлээх үүргийг тодорхойлсон. Үүнд Засгийн газар хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж, эдийн засгийн зохицуулалтын үр нөлөө, эрх зөрчигдсэн болон нөхөн төлбөр олгосон тохиолдол, шударга өрсөлдөөний орчны талаарх мэдээллийг тайлагнахаар тусгасан. Мөн эдийн засгийн эрх чөлөөг сэргээх арга хэмжээ, төрийн өмчит компанийн талаар баримтлах бодлогыг олон нийтэд ил тод мэдээлж, Улсын Их Хуралд танилцуулах үүргийг Засгийн газарт хүлээлгэсэн.

Тавдугаар бүлгээр энэ хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор бусад хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, аргачлалыг уг хуульд нийцүүлэх зохицуулалтыг тусгасан. Мөн эдийн засгийн харилцааг зохицуулах хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцэх явцад эдийн засгийн эрх чөлөөнд үзүүлэх нөлөөллийг үнэлэх шаардлагыг хангах эрх зүйн үндсийг тогтоож, хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг тодорхойлсон.

Монгол Улсын эдийн засгийн орчны бодит байдлыг оношлохдоо бид АНУ-ын "Heritage Foundation"-ийн 1995 оноос хойш жил бүр эрхлэн гаргадаг "Эдийн засгийн эрх чөлөөний индекс"-ийн түүхэн мэдээлэл, Канадын "Fraser Institute"-ийн "Дэлхийн эдийн засгийн эрх чөлөө" тайлан, "Transparency International" байгууллагын "Авлигын төсөөллийн индекс", "World Justice Project"-ийн "Хууль дээдлэх ёсны индекс" зэрэг олон улсын харьцуулсан, стандартчилагдсан үнэлгээнүүдэд гүнзгий дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн, Дэлхийн Банк, Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банкны Монгол Улсын эдийн засаг, засаглалын талаарх үеийн тайлан, зөвлөмжүүд, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас эрхлэн гаргадаг "Бизнесийн итгэлийн индекс", Үндэсний Статистикийн Хорооны макро эдийн засгийн болон нийгмийн үзүүлэлтүүдийг ашиглан асуудлыг дотоодын нөхцөл байдалтай нягт уялдуулсан. Онолын болон философийн үндэслэлийг боловсруулахдаа бид эдийн засгийн шинжлэх ухаанд Нобелийн шагнал хүртсэн Дуглас Норт, Фридрих фон Хайек, Милтон Фридман зэрэг сэтгэгчдийн институцийн эдийн засаг, эрх чөлөөт нийгмийн талаарх сонгодог бүтээлүүдээс эш татаж, харьцуулсан эрх зүйн шинжилгээ хийхдээ Эстони, Польш, Чили, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг эдийн засгийн шилжилтийг амжилттай хийсэн орнуудын Үндсэн хууль, холбогдох хууль тогтоомжийн түүхэн туршлагыг нарийвчлан судалсан болно.

Олон улсын туршлага

"Эдийн засгийн эрх чөлөөний тухай" хуулийн төслийн үзэл баримтлалтай нийцэж буй, эдийн засгийн шилжилтийг амжилттай хийсэн зарим улс орны Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн холбогдох хэсгийн албан бус орчуулгыг жишээ болгон харуулав.

1. Эстони Улсын Үндсэн хууль (As of 2015)

- **§ 31.** Эстонийн иргэн бүр аж ахуй эрхлэх, ашгийн төлөөх нэгдэл, холбоодод нэгдэх эрхтэй. Хуулиар энэхүү эрхийг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг тогтоож болно, хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол энэ нь Эстонид байгаа гадаадын улсын иргэн, харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.
- **§ 32.** Хүн бүрийн өмч халдашгүй байна. Өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр өмчийг хураахыг зөвхөн хуульд заасан тохиолдолд, нийтийн ашиг сонирхлын үүднээс, шударга бөгөөд нэн даруй нөхөн олговор олгосны үндсэн дээр зөвшөөрнө. Нөхөн олговрын хэмжээг тодорхойлох арга зам болон маргааныг шүүхээр шийдвэрлэнэ.

2. Бүгд Найрамдах Польш Улсын Үндсэн хууль (As of 1997)

- **20 дугаар зүйл.** Нийгмийн зах зээлийн эдийн засаг нь хувийн өмч, эдийн засгийн эрх чөлөө, ажил олгогч, ажилтан, хэрэглэгчдийн эв санааны нэгдэл, яриа хэлэлцээ, хамтын ажиллагаанд суурилсан бөгөөд Бүгд Найрамдах Польш Улсын эдийн засгийн тогтолцооны үндэс байна.
- **22 дугаар зүйл.** Эдийн засгийн үйл ажиллагааны эрх чөлөөг хязгаарлах нь зөвхөн хуулиар, зөвхөн нийтийн чухал ашиг сонирхлыг үндэслэн хийгдэнэ.

3. Бүгд Найрамдах Чили Улсын Үндсэн хууль (As of 2022)

- **19 дүгээр зүйлийн 21 дэх хэсэг.** Аливаа эдийн засгийн үйл ажиллагааг эрхлэх эрх. Төр болон түүний байгууллагууд нь аж ахуйн үйл ажиллагааг хөгжүүлэх эсвэл зөвхөн хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд л түүнд оролцоно.
- **19 дүгээр зүйлийн 24 дэх хэсэг.** Өмчийн эрхийг түүний янз бүрийн төрлөөр нь баталгаажуулна. Зөвхөн хууль нь өмчлөх эрхийг ашиглах, эдлэх, захиран зарцуулах арга замыг тогтоож, нийгмийн үүргээс нь үүдэн гарах хязгаарлалтыг тогтоож болно. Хэнийг ч өөрийн өмчөөс нь, эсвэл түүнийг эдлэх эрхээс нь салгаж үл болно, үүнийг зөвхөн нийтийн ашиг тусын үүднээс, эсвэл үндэсний ашиг сонирхлын дагуу, хуулиар тогтоосон тохиолдолд, урьдчилан тохиролцсон нөхөн олговрыг төлсний үндсэн дээр хийнэ.

4. Ирланд Улсын Үндсэн хууль (As of 2019)

- **43 дугаар зүйл. 1.** Төр нь хувийн өмчийн эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрх нь нийгмийн шударга ёсны дагуу, нийтийн сайн сайхны төлөөх зарчимд нийцүүлэн төрөөс зохицуулагдах болно.
 - **2.** Иймээс Төр нь хувийн өмчийн эрхийг хэрэгжүүлэхэд нийтийн сайн сайхны төлөөх шаардлагаар хязгаарлалт тогтоож болно. ... Аливаа өмчийг хууль бусаар хураахыг хориглоно.

(Энэхүү хавсралтад бусад улсын холбогдох хуулийн заалтыг нэмж оруулах боломжтой)

Энэхүү дэлгэрэнгүй танилцуулгад "Эдийн засгийн эрх чөлөөний тухай" хуулийн төсөл нь улс орны эдийн засгийн харилцааны эрх зүйн суурийг нэгтгэн цэгцлэх, Үндсэн хуульд тунхагласан иргэний эдийн засгийн суурь эрхийг бодит агуулгаар баталгаажуулах, улмаар хууль хэрэглээний нэгдмэл практикийг бий болгох замаар эрх зүйн орчны тогтвортой, урьдчилан таамаглахуйц байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн цогц зохицуулалт болох нь харагдаж байна. Хуулийн төсөл нь өөрийн мөн чанарын хувьд шинээр үүрэг, хариуцлага, хүнд суртал бий болгох бус, харин одоогийн эрх зүйн орчинд оршиж буй зөрчил, хийдлийг арилгаж, эдийн засагт оролцогчдын хувьд "тоглоомын дүрэм"-ийг илүү ойлгомжтой, энгийн, шударга болгох зорилгыг агуулж байна.

Өмчийн эрхийн халдашгүй байдлыг баталгаажуулсан, татварын орчны тогтвортой байдлыг хангах, гэрээний эрх чөлөөг хүндэтгэх, аж ахуй эрхлэх, чөлөөтэй өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зэрэг хуулийн төсөлд тусгагдсан суурь зарчмууд нь тус бүрдээ болон нийлбэр дүнгээрээ хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, жижиг, дунд бизнесийн хөгжлийг дэмжих, улмаар эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, тогтвортой өсөлтийг хангах зэрэг үр дагавартай болохыг энэхүү шинжилгээний үр дүн харуулж байна. Түүнчлэн, төрийн зүгээс иргэний эдийн засгийн эрх, эрх чөлөөнд халдах нөхцөл, хязгаарыг тодорхой болгож, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах механизмыг тусгаж өгсөн нь хуулийн засаглалыг бэхжүүлэх, иргэд, аж ахуйн нэгжийн төрд итгэх итгэлийг сэргээхэд чухал ач холбогдолтой юм.

-oOOo-

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангах, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаалах зарчимд тулгуурлан хувь хүний эдийн засгийн суурь эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хувийн өмчийн эрх, гэрээний эрх чөлөө, хөдөлмөр ба хөрөнгө оруулалтын үр шимийг хамгаалах, шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх, төрийн оролцоог хязгаарлах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тогтвортой орчныг бүрдүүлэх, аж ахуйн эрхлэгчийн ажил хэргийн нэр хүндийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж

2.1.Эдийн засгийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг батлах, тайлбарлах, хэрэглэхдээ энэ хуульд заасан эдийн засгийн эрх чөлөөний зарчим, баталгааг баримтална.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хуулиар хориглосноос бусад эдийн засгийн харилцаанд хамаарна.

3.2.Эдийн засгийн харилцааг зохицуулсан хууль тогтоомж нь энэ хуульд заасан эдийн засгийн эрх чөлөөний зарчимд нийцсэн байна.

4 дүгээр зүйл.Нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“аж ахуй эрхлэгч” гэж Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.3-т заасныг;

4.1.2.“аж ахуйн нэгж” гэж Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

4.1.3. “аж ахуйн үйл ажиллагаа” гэж бараа борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх болон түүнтэй адилтгах үйл ажиллагааг;

4.1.4. “шударга өрсөлдөөн” гэж зах зээлд оролцогчид хуульд нийцсэн, тэгш нөхцөлд чөлөөтэй өрсөлдөх орчныг;

4.1.5. “эдийн засгийг зохицуулах” гэж Үндсэн хуулийн 5.4-т заасныг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

5 дугаар зүйл. Эдийн засгийн эрх чөлөө

5.1. Аж ахуй эрхлэгч дараах эрхийг эдэлнэ:

5.1.1. хууль ёсоор олж авсан өмч хөрөнгө нь халдашгүй байх;

5.1.2. хөдөлмөр, оюуны бүтээл, хөрөнгө оруулалтын үр шим, хууль ёсны дагуу олсон орлогоо чөлөөтэй эзэмших, ашиглах, захиран зарцуулах;

5.1.3. хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг бие даан тодорхойлох;

5.1.4. хуулиар хориглосноос бусад аж ахуйн үйл ажиллагааг хуулийн дагуу чөлөөтэй эрхлэх;

5.1.5. хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга өрсөлдөх;

5.1.6. хууль ёсны мөнгөн тэмдэгт болон бусад төлбөрийн хэрэгслийг чөлөөтэй эзэмших, ашиглах, солилцох;

5.1.7. хуулиар тогтоосон нууцад хамааралтай мэдээлэл нь халдашгүй байх;

5.1.8. ажил хэргийн нэр хүнд нь хууль бус халдлагаас ангид байх.

5.2. Эдийн засгийн эрх чөлөөг хүний бусад үндсэн эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах зорилгоор зөвхөн хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.

5.3. Эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь дараах шаардлагыг хангасан байна:

5.3.1. Үндсэн хуулийн 5.4-т заасан зорилгод нийцсэн байх;

5.3.2. Хуулиар тогтоосон байх;

5.3.3. Хязгаарлалт нь зорилгодоо хүрэхэд тохирсон, боломжит хамгийн бага түвшинд байх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ БАТАЛГАА

6 дугаар зүйл. Төрөөс эдийн засгийг зохицуулах бүрэн эрх, түүний хязгаар

6.1. Төр нь эдийн засгийг Үндсэн хууль болон энэ хуульд заасан хүрээнд зохицуулна.

6.2.Төр нь эдийн засгийг зохицуулахдаа аж ахуй эрхлэгчийн Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлнэ.

6.3.Төрөөс эдийн засагт аливаа хэлбэрээр оролцохдоо аж ахуй эрхлэгчтэй үл өрсөлдөх, хуульд заагаагүй давуу эрх эдлэхгүй байх зарчмыг баримтлах бөгөөд өөрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгаж олон нийтийн хяналт тавих боломжийг хангана.

7 дугаар зүйл.Өмчлөх эрхийн баталгаа

7.1.Төр нь өмчийн халдашгүй байдлыг хангаж, өмчлөгчийн эрхийг хамгаалах үүрэгтэй.

7.2.Өмчлөх эрхийг хязгаарлах аливаа шийдвэр, үйл ажиллагаанд Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон энэ хуулийн 5.3-т заасныг баримтална.

7.3.Хувийн өмчийг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн дайчлан авах, хураах төрийн байгууллагын шийдвэр нь зөвхөн зах зээлийн бодит үнэлгээнд үндэслэсэн нөхөх олговор бүрэн төлөгдсөн тохиолдолд хэрэгжинэ.

7.4.Төр нь хөрөнгийн эрхийг баталгаажуулах хуульд заасан бүртгэлийн тогтолцоо болон өмчлөгчийн эрхийг нотлох хууль эрх зүйн орчноор хангах үүрэгтэй.

8 дугаар зүйл.Татвар тогтоох зарчим

8.1.Аж ахуй эрхлэгчийн ашиг, орлого, хөрөнгөд ногдуулах татварыг зөвхөн татварын хуулиар тогтооно.

8.2.Хуульд заагаагүй төлбөр, хураамж, шимтгэл ногдуулахыг хориглоно.

8.3.Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн нэгдсэн бодлогыг хуулиар тодорхойлж, ашгийн бус, нийгэмд тустай үйл ажиллагааг дэмжинэ.

8.4.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээд татварын аливаа хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхгүй.

8.5.Татварын харилцааг хуулиар нарийвчлан зохицуулна.

9 дүгээр зүйл.Гэрээний эрх чөлөө

9.1.Төр нь гэрээний талуудын хүсэл зориг, гэрээний нөхцөлийг хүндэтгэнэ.

9.2.Төр нь гэрээний нөхцөлийг хүчингүй болгох, гэрээ биелэгдэх боломжийг өөрчлөх үр дагавартай, аж ахуй эрхлэгчийн эрх зүйн байдлыг дордуулах буцаан үйлчлэх хууль тогтоохыг хориглоно.

9.3.Төр нь гэрээний маргааныг шүүхийн бус эвлэрүүлэн зуучлал, арбитрын журмаар шийдвэрлэх боломжийг дэмжиж, маргааныг шуурхай, шударга, хараат бус байдлаар шийдвэрлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

9.4.Төр нь хүчин төгөлдөр гэрээний биелэлтийг хангахын тулд албадан гүйцэтгэх тогтолцоог бүрдүүлж, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор түүнийг заавал биелүүлэх баталгааг хангах үүрэгтэй.

9.5.Төр гэрээний нэг тал болсон тохиолдолд хуульд заасны дагуу уг гэрээний нөхцөлийг олон нийтэд ил тод болгож, түүний хэрэгжилт, биелэлтийг хянан үнэлэх эрх зүйн нөхцөлийг бүрдүүлж, иргэд, олон нийтийн хяналт тавих боломжийг хангана.

10 дугаар зүйл.Аж ахуй эрхлэх эрх

10.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн, хуулийн этгээд хуулиар хориглоогүй аж ахуйн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх эрхтэй.

10.2.Эдийн засгийн харилцааг зохицуулсан аливаа хууль тогтоомж, төрийн байгууллагын шийдвэр үндэслэл бүхий, тодорхой, нийтэд ойлгомжтой, ил тод байх бөгөөд төр нь эрх зүйн орчны тогтвортой байдлыг хангах үүрэгтэй.

10.3.Аж ахуй эрхлэхтэй холбоотой зөвшөөрлийн тогтолцоо нь хамгийн бага хязгаарлалттай байх зарчимд тулгуурлах бөгөөд зөвшөөрөл олгох зайлшгүй шаардлагатай нөхцөлийг зөвхөн хуулиар тогтооно.

10.4.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн байгууллага хуульд заасан хугацаанд шийдвэр гаргаагүй тохиолдолд холбогдох зөвшөөрлийг олгосонд тооцно.

10.5.Төрөөс аж ахуй эрхлэгчид үйлчилгээ үзүүлэхдээ зөвхөн хуульд заасан баримт бичиг, түүний бүрдлийг шаардана.

10.6.Аж ахуй эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт, шалгалт хийх, хуульд заасан хугацааг хэтрүүлэхийг хориглоно.

10.7.Төр нь аж ахуй эрхлэгчдэд хэрэгцээт мэдээллийг үнэ төлбөргүй, цахим хэлбэрээр тогтмол хүргэж, төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцыг ил тод, нээлттэй байлгана.

10.8.Аж ахуй эрхлэгч нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээг дагаж мөрдөнө.

10.9.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээтэй холбоотой харилцааг хуулиар нарийвчлан зохицуулна.

11 дүгээр зүйл.Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга өрсөлдөх эрх

11.1.Аж ахуй эрхлэгчид хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

11.2.Төр нь эдийн засагт чөлөөт, шударга өрсөлдөөний орчныг бүрдүүлэх үүрэгтэй.

11.3.Төрөөс хуульд зааснаас бусад үндэслэлээр зах зээлийн харилцаанд хязгаарлалт тогтоох, ялгаварлан зохицуулахыг хориглоно.

11.4.Зүй ёсны монополь болон давамгайлалтай аж ахуйн эрхлэгчийн үйл ажиллагаа болон хууль бус өрсөлдөөнийг хянах, таслан зогсоох харилцааг хуулиар нарийвчлан зохицуулна.

11.5.Төрөөс үнэ тогтоох, нийлүүлэлтийг хязгаарлах зэрэг өрсөлдөөнийг саатуулах шийдвэр гаргахдаа энэ хуулийн 5.3-т заасныг баримтлах бөгөөд аливаа хязгаарлалтыг зөвхөн тодорхой, түр хугацаанд тогтооно.

11.6.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийг зөвхөн нийтийн ашиг сонирхлыг хангах зайлшгүй шаардлагатай тохиолдолд үүсгэн байгуулна.

11.7.Төр аж ахуй эрхлэх, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд үүсгэн байгуулах, удирдах, татан буулгахтай холбоотой харилцааг хуулиар нарийвчлан зохицуулна.

11.8.Төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авалт нь ил тод байх, үл ялгаварлах зарчимд үндэслэн аж ахуй эрхлэгчдийн эдийн засагт чөлөөтэй, шударга өрсөлдөх эрх чөлөөг хангасан байна.

11.9.Төр нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтад үндэслэлгүй саад тавихгүй бөгөөд үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээтэй уялдуулан хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаална.

11.10.Банкны үйл ажиллагаа эрхлэгч нь Банкны тухай хуулиар зөвшөөрснөөс өөр төрлийн үйл ажиллагааг давхар эрхлэхийг хориглоно.

12 дугаар зүйл.Мөнгө, санхүүгийн харилцаан дахь эрх чөлөө

12.1.Аж ахуй эрхлэгч нь хуульд өөрөөр заагаагүй бол мөнгө, гадаад валют, үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхтэй.

12.2.Төрөөс мөнгө, санхүүгийн харилцааг зохицуулахдаа зах зээлийн чөлөөт үйл ажиллагаа, өмчлөх эрх, гэрээний эрх чөлөөг хүндэтгэнэ.

12.3.Төрөөс мөнгө, санхүүгийн харилцаанд оролцохдоо үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн үнэ, хүү, ханш болон хөрөнгийн хөдөлгөөнд захиргааны аргаар хязгаарлалт тогтоохоос зайлсхийх бөгөөд энэ төрлийн хязгаарлалтыг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэнэ.

12.4.Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 5.3-т заасан шаардлагыг хангасан нөхцөлд мөнгө, санхүүгийн харилцаанд хязгаарлалт тогтоож болно.

12.5.Аж ахуй эрхлэгчийн үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслийг эзэмших, гаргах, шилжүүлэх, захиран зарцуулах эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлаж болно.

13 дугаар зүйл.Аж ахуй эрхлэгчийн мэдээллийн халдашгүй байдал

13.1.Төр нь аж ахуй эрхлэгчийн мэдээллийн халдашгүй байдлыг хангах үүрэгтэй.

13.2.Эрх бүхий этгээд аж ахуй эрхлэхтэй холбоотой хувь хүний болон байгууллагын мэдээлэлтэй зөвхөн хуульд заасан үндэслэлээр танилцаж болно.

13.3.Аж ахуй эрхлэгчийн аливаа мэдээлэлд хуульд зааснаас бусад аргаар халдахыг хориглоно.

13.4.Аж ахуй эрхлэгч нь өөрийн аж ахуй эрхэлсний үр дүнд бий болгосон мэдээллийг ашиглах, хадгалах, хамгаалах эрхтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХАРИУЦЛАГА, ШҮҮХИЙН ХАМГААЛАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ, ХЯНАЛТ

14 дүгээр зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтны хариуцлага

14.1.Төрийн эдийн засгийг зохицуулах үйл ажиллагаа нь ил тод, хэмжигдэхүйц байх бөгөөд холбогдох төрийн байгууллагууд тогтмол хугацаанд олон нийтэд тайлагнах үүрэгтэй.

14.2.Төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаа, үйлдэл эс үйлдэхүйгээс аж ахуй эрхлэгчид учирсан хохирлыг төр хуульд заасны дагуу нөхөн төлнө.

14.3.Энэ хуулийг зөрчсөн төрийн байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

14.4.Хариуцлага тооцох зорилго нь аж ахуй эрхлэгчийн эдийн засгийн эрхийг сэргээж, төрийн хариуцлагыг бэхжүүлэхэд чиглэнэ.

15 дугаар зүйл.Шүүхийн хамгаалалт

15.1.Аж ахуй эрхлэгч төрийн хууль бус шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд төрийн байгууллага гомдлыг хуульд заасан хугацаанд шуурхай шийдвэрлэх, эрхийг сэргээх, нөхөн төлбөрийг барагдуулах үүрэгтэй.

15.2.Эдийн засгийн эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзсэн аж ахуй эрхлэгч захиргааны байгууллага болон шүүхэд холбогдох хууль, дүрэм журмын дагуу хандан зөрчигдсэн эрхээ сэргээлгэх эрхтэй.

15.3.Эдийн засгийн эрх чөлөөг хязгаарлах шийдвэрийг энэ хуулийн 5.3 болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн эсэхийг төр нотлох үүрэгтэй.

16 дугаар зүйл.Ил тод байдал, хяналт

16.1.Засгийн газар энэ хуулийн хэрэгжилтийн тайланг жил бүр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж, хэлэлцүүлнэ.

16.2.Тайланд дараах мэдээллийг заавал тусгана:

16.2.1.төрөөс эдийн засгийн зохицуулалт хийсэн хүрээ, арга хэлбэр, үр нөлөөний тоон үзүүлэлт;

16.2.2.эдийн засгийн эрх зөрчигдсэн, нөхөн төлбөр олгосон тохиолдлын тоо, хэмжээ;

16.2.3.ил тод байдал, шударга өрсөлдөөний орчны талаарх дүн шинжилгээ.

17 дугаар зүйл.Засгийн газрын эрх, үүрэг

17.1.Энэ хуулийн 16.1-т заасан тайланг Засгийн газар жил бүр Улсын Их Хурлын хаврын чуулганы нээлтийн долоо хоногт танилцуулна.

17.2.Засгийн газар эдийн засгийн эрх чөлөөг сэргээх шийдвэрийн биелэлт, хохирол барагдуулсантай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод байдлаар мэдээлж, тогтмол тайлагнана.

17.3.Төрийн өмчит компанийн талаар баримтлах бодлогыг энэ хууль болон холбогдох хуульд нийцүүлэн Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

18 дугаар зүйл.Бусад хууль тогтоомжийг нийцүүлэх

18.1.Бусад хууль тогтоомжид энэ хуульд зааснаас өөрөөр заасан заалт, зохицуулалтыг дараах журмаар энэ хуульд нийцүүлнэ:

18.1.1.Үндсэн хууль болон Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу энэ хуульд нийцүүлэх ажлыг Засгийн газраас зохион байгуулна.

18.1.2. хууль санаачлагч нь шүүхийн шийдвэр болон иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг үндэслэн энэ хуульд нийцүүлэх ажлыг зохион байгуулж болно.

18.2.Энэ хуульд зааснаас өөрөөр заасан нийтээр дагаж мөрдөх журам, заавар, аргачлалыг энэ хуульд заасантай нийцүүлэх үүргийг тухайн дүрэм, журам, заавар, аргачлалыг боловсруулж баталсан захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

18.3.Эдийн засгийн харилцааг зохицуулахтай холбоотой хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг хэлэлцэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 17.2.5-д заасан шаардлагыг хангуулна.

19 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

19.1.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.2.5 дахь заалт нэмсүгэй:

“17.2.5.Эдийн засгийн эрх чөлөөний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т заасан шаардлагыг хангасан байдлыг үнэлэх.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ӨРСӨЛДӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Өрсөлдөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"4.1.3."аж ахуй эрхлэгч" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт аж ахуй эрхэлж байгаа ашгийн төлөө болон ашгийн төлөө бус хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, хувь хүнийг;"

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь хэсэг нэмсүгэй:

“13.Эрх бүхий этгээд хуульд заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол аж ахуй эрхлэхтэй холбогдох зөвшөөрлийг олгосонд тооцно.”

Гарын үсэг